

ХЭЛНИЙ ЭКОЛОГИ

Ш.Чоймаа¹

"Экология" хэмээх үг нь грек гаралтай бөгөөд "oikos"-орон байр, орших газар, "logos"- судлал, сургаал гэсэн нийлмэл үг юм. "Оршихуйн судлал" хэмээсэн утгатай "экологи" гэсэн нэр томъёог анх германы биологич Эрнст Геккель 1866 онд² хэрэглэсэн түүхтэй аж.

Аливаа амьд бие махбод өөр хоорондоо болон оршин буй орчиндоо хэрхэн зохицож, хэрхэн харилцан нөлөөлж байгааг судлах ухааныг "экологи" хэмээдэг. Сав, шим ертөнцийн өчүүхэн нэгэн хэсэг болох хүмүүн хэмээх амьтны аминч үзэл, буруутай үйл үйлдлээс байгалийн тэнцвэрт харьцаа алдагдаж, байгалийн дасан зохицох заяагдмал чадамжаас нь хэтэрсэн өнөө үед экологи хэмээх үг, ухагдахууны утга, хэрэглээ нэн дэлгэр болжээ.

"Экологи нь цэвэр биологийн шинжлэх ухааны салбар боловч байгаль, нийгмийн ухааны олон салбарт уг нэрийг буруу ташаа хэрэглэх байдал манай орны хувьд түгээмэл болоод байна"³ хэмээн манай биологичид бичсэн байна.

Өнөөдөр, дэлхий дахинд шинжлэх ухааны олон салбар нарийсаж хөгжихийн хамт, олон шинжлэх ухааны зааг дахь судалгаа олширч өгөөж үр дүн нь ч элбэг байх болжээ. Экологи хэмээх ойлголтыг өмчирхөх хэрэггүй бөгөөд биологийн ухааны экологи хэмээх салбарт амжилт гаргах нэг үндэс нь уг ухагдахууныг өргөн хүрээнд ухаарч, хүмүүний оюун санааны ертөнцийн үйл үйлдэлтэй сайтар холбох явдал байж болох юм.

Сүүлийн үед экологи хэмээх үгийн "хамгаалах" гэсэн утга санааг нэн эрхэмлэж, байгалийн ухаан төдийгүй хүмүүнлиг, нийгмийн ухаанд ч хэрэглэх болов. Соёлын экологи, хэлний экологи, оюун санааны экологи (экология духа), шашны экологи хэмээн бичиж, судалгааны бүтээлүүд гарах боллоо.

Миний бие хэлний экологи хэмээх том сэдвийн хүрээнд цөөн зүйлийг өгүүлнэ.

Хэлний экологи гэж юу вэ? гэдэгт эрдэмтэн судлаачид хариулахдаа:

"Сэтгэхүй болон хэлэхүйн төрх байдлын соёл, хэл шинжлэлийн нарийн мэдрэмжийн хүмүүжил, бичгийн хэлийг хамгаалах болон "эрүүлжүүлэх", бас баяжуулан төгөлдөржүүлэх арга замыг зөв тодорхойлж, ажил хэрэг болгох үйл, хэл ярианы гоо зүй зэргийг багтаана"⁴ гэжээ.

¹ ШУ-ы доктор, дэд профессор. МУИС-ийн Монгол хэл, соёлын сургууль.

² Философский энциклопедический словарь, Москва, ИНФРА - М, 2004, стр. 535

³ Болджав, Б., Батсайхан, Б.Н., "Экологийн нэр томъёоны Англи - Монгол толь" УБ. 2007, 141-р тал.

⁴ Хроленко, А.Т., Бондалетов, В.Д., "Теория языка", учебное пособие для студентов, аспирантов и преподавателей - филологов, Москва, 2004, стр.397

Хүн хэмээх ухаант амьтан, сайны хажуугаар саарыг сэтгэж, алс хэтийг бус амар дөхмийг эрхэмлэх нисваанист араншинг бас сэтгэлдээ агуулж байдаг. Тэр араншин нь өөртөө хамаатай бүхнийг аль болох хялбар байлгах, өнөө маргаашийн хэрэгцээг төвөг багатай хангах гэсэн сэтгэлгээний нийтлэг "залхуу" хандлагыг буй болгодог. Энэ хандлагад өнөөгийн глобальчлал буюу даяарчлал хэмээх үзэгдэл улам ташуур өгч байна. Энэ бүхэн нь аливаа улс үндэстний хэл бичиг, соёл, ёс заншил, шашин шүтлэг зэрэг өвөрмөц хэв шинжийг үл хайхардаг төдийгүй шууд аюул занал учруулж байна. Ийм нөхцөл байдал буй болсон өнөө үед хэлний экологийг онцгойлон анхаарах хэрэгтэй болжээ. Хэрвээ аль нэгэн улс үндэстэн өөрийн соёлоо хадгалан хамгаалж, хөгжүүлэн алдаршуулах хэмээвээс тухайн соёл оршихуйн язгуур үндэс болсон эх хэлээ анхааран үзэж, үндэстнийхээ сэтгэлгээний өвөрмөц дүр төрхийг мэдэх нэвтэрхий толь болсон аман болон бичгийн хэлнийхээ өв санг сайтар эзэмшиж, судалж, сурталчилж, хойч үедээ залгамжлуулах ёстой. Энэ нь тухайн улс үндэстний тусгаар тогтнолтой шууд холбоотой асуудал юм. Хэлний экологи нь соёлын экологийн асуудлын язгуур үндэс нь юм. Оросын эрдэмтэн Мамардашвили "Хэл ба соёл" хэмээх өгүүлэлдээ "Хэл өөрөө, соёл оршин тогтнохын боломж нөхцөл юм" (Язык - это сама возможность существования культуры)⁵ гэжээ.

Ер нь "экологи" хэмээх ойлголт нь орчин үед "унаган төрхийг нь хамгаалах, нөхөн төлжүүлэх" хэмээсэн гол агуулгыг илэрхийлж, сав шимийн ертөнц хийгээд оюун санааны ертөнцийн зохист тэнцвэрт орчныг хэвээр нь хадгалах, тийм боломж нөхцөлийг бүрдүүлэх, түүнд харшлах аливаа үйлдэлтэй эрс тэмцэх зэргийг гол зорилгоо болгож байна. Хэрвээ хүн төрөлхтөний оюун санааны ертөнц, түүний өв санг хамгаалах хэмээвээс тулгуур үндэс нь болсон хэлийг хамгаалах ёстой. Мэдээж хэрэг, хэл гэдэгт эрт эдүгээгийн олон хэл, аялгуунууд, тэдгээр хэл аялгуугаар бүтээсэн аман зохиолын болон бичгийн зохиолын олон зуун жилийн гайхамшигт оюуны баялгийг багтаан хэлж байна.

Өмнө өгүүлсэнтэйгээ болон ер нь хэлний экологийн тухай өгүүлэхэд, академич Ш.Лувсанвандан багшийн "Хүний хэлийг их, бага үндэстэн ярьдаг гэж ялгалгүй адилхан хөгжүүлсе" хэмээсэн өгүүллийг эш татах нь зүйтэй билээ. Лу багштан бээр бичихдээ:

"Одоо байгаль орчныг хамгаалах талаар их ярьж байна. Амьтан ургамлын олон янз болсныг, хувиран өөрчлөгдсөний үнэт өв гэж нэг ч амьтан ургамлын төрлийг таслахгүй хамгаалах зорилт тавьж байна. Бидний бодоход хүний хэл, соёл, арьс олон янз болсон нь бас хувиран өөрчлөгдсөний үнэт өв болох тул нэг ч соёл, хэлийг үлдээлгүй хайрлан хөгжүүлэх хэрэгтэй болж байна.

Амьтан ургамал, хүний хэл, соёл, арьсны ингэж олон янз, олон үе болсон нь орчин харилцан адилгүй болсон тул орчинтойгоо зохицох гэсэн ийм олон янз, олон үе болсон байна. Энэ учраас эдгээр амьтан, ургамал, хүний хэл, соёл, арьсыг цөөлөх гэвэл мөн орчныг цөөлөх гэсэн хэцүү ажил гарч ирнэ ...

Нэг хэл аялгуунд нөгөө хэл аялгуу, ялангуяа зэрэгцэн суусан газар нөлөөгүй тийм цэвэр хэл, аялгуу гэж байдаггүй нь нэг хэл, аялгуу нөгөөдөө орчин нь болдгийг харуулж байна ... Ийм нөхцөл байдалд нэг хэл соёлтой, нэг арьстан болгох зорилт тавибал одоогийн байгаа хэл, соёл, арьсыг устгах хэрэг болох юм. Харин олон хэл, соёл, арьс

⁵ Хроленко, А.Т., Бондалетов, В.Д., "Теория языка", учебное пособие для студентов, аспирантов и преподавателей - филологов, Москва, 2004, стр. 395

зэрэг хөгжих зорилго тавих нь байгаль, нийгмийн хуулинд илүү тохирч, олон хэлтэн, соёлтон, арьстан хамтран ажиллах бололцоо гарч ирнэ ...

Аж үйлдвэрийг хөгжүүлэхэд орон нутгийн бололцоог сайн ашиглах хэрэгтэй гэдэгтэй адил нийт хүн төрөлхтөний хэл, соёлыг хөгжүүлэхэд нутаг нутгийн хэл, соёлыг бас нэг адил хөгжүүлэх хэрэгтэй байна"⁶ хэмээсэн билээ. Лу багштан маань 20 гаруй жилийн тэртээ бичсэн энэ өгүүлэл, өнөөдөр улам үнэ цэнтэй болж байх тул дээр дэлгэрэнгүй эш татлаа.

Хэл шинжээчдийн тооцоолсноор, манай дэлхийн 5 тэрбум гаруй хүн 3000 орчим хэлээр харьцаж байгаа аж. Хэрэв нутгийн аялгуу, түүний аман аялгууг, хэлтэй нь хамт тоолбол 25000-30000 орчим хэмээсэн бүртгэл буй. Тэдгээр олон хэл, аялгууны цаана тухайн үндэстэн, ястны түүх соёлын хувьсал хөгжлийн зам мөр, хэл сэтгэлгээний өвөрмөц онцлог, урлаг соёл, ёс заншил, зан үйл, шашин шүтлэг зэргээрээ ялгарсан янз янзын төрх байдал оршиж байгаа бөгөөд тийм олон зүйл орчин нөхцөл оршин байж гэмээ нь хүн төрөлхтөний оюуны ертөнц утга учиртай, гэрэл гэгээтэй болох буй заа.

Хэл соёлын экологийн тухай авч үзэхэд, иргэншил (соёл иргэншил гэж нэрлэхээс татгалзав. Уг үг нь "civis-иргэн" гэсэн латин үгээс гаралтай бөгөөд соёл хэмээх үгийг хоршуулах нь оновчтой бус гэж үзэв. Ш.Ч)-ийн тухай асуудал хөндөгдөнө. Хэлний экологи нь тухайн үндэстний соёлын экологитой салшгүй холбогддог бол иргэншил (цивилизация) хэмээх ойлголт нь анхнаасаа л дэлхийн улс үндэстэн, хүн ардыг басамжлан ялгаварлах, "соёлтой" хэмээсэн нь өөрийнхөө хэл, соёл, амьдралын хэвшилтэй бусдыг жишин үнэлэх хандалгатай байсан. Түүнээс үүдэн, иргэншил (цивилизация)-ийг нийгмийн хөгжлийн үе шат хэмээн үзэх нь европ дахинд түгээмэл болсон. Энэ талаар профессор А.Цанжид "Монгол соёл иргэншил" хэмээх номдоо:

"Соёл иргэншил (цивилизация) гэдэг ойлголтыг хөгжлийн үе шаттай холбон үзэх болсон нь түүхэн тодорхой нөхцөлтэй бас холбоотой юм. Ийм хандлагын эх үүсвэр нь европчууд дэлхийн бусад нутагт байгаа хөгжлөөр дорой ард түмнүүдтэй харьцаж, тэдний амьдрал ахуйг судлан, тэд-бид гэх юм уу, тэд бүдүүлэг-бид хөгжсөн гэх маягийн үзлээс гаралтай юм. Ийм хандлага бүр эртний Ромын үед ч гарч байв. Ромын боол эзэмшигчид өөрсдийгөө бусдаас ялгаж "civis romanus" (ромын иргэд) гэж нэрлээд бусдад бүдүүлэг хэмээх нийтийг багтаасан нэр өгч байсан юм"⁷ хэмээн бичжээ. Ер нь эрт үеэс суурьшмал улс иргэд өөрсдийгөө "боловсон" хэмээн үзэж, бусдыг бүдүүлэг гэх үзэл түгээмэл байсан бөгөөд дорно дахинд эртний хятадад бас тийм үзэл байсан билээ. Энэ байдал нь аажмаар аж үйлдвэрийн хувьсгал, шинжлэх ухаан техникийн хөгжилтэй уялдан, европ дахиныг дэлхийн бусад хэсгээс ялгах ойлголт мэт болжээ. Өнөө үед иргэншил (цивилизация) хэмээх ойлголтод соёл, шинжлэх ухааны ололт амжилт, хүний амьдрах орчин мэтийг багтаах болсон хэдий ч, ямар нэг байдлаар улс үндэстнийг ялгаварлан нэрийдэх байдал хэвээр байна. Энэ байдал нь хэлний экологи, соёлын экологид харшилдаг төдийгүй тухайн улс үндэстний дотор гадны орныг тухайлбал, өрнөдийн орны аливаа бүхнийг сохроор шохоорхон дуурайх хандлагыг буй болгож, өөрийн хэл соёл, ёс заншил, уламжлалыг үл тоомсорлогчид олшрох үзэл бодлын хийсвэр орчин нөхцөл болсоор байна. Энэ нь нэгэн зүйл "нялхас"-ын өвчин юм. Хэлний экологийн тухайд, үндэстний соёл болон иргэншил (цивилизация) гэдэг ойлголтууд нь бараг эсрэгцэх байртай тул дээрх зүйлийг товч дурдлаа.

⁶ Лувсанвандан, Ш. "Хүний хэлийг их, бага үндэстэн ярьдаг гэж ялгалгүй адилхан хөгжүүлсе", Хэл, харилцаа, дохио, (Бүтээлийн түүврийн V боть), УБ, 2005, 242, 243-р тал.

⁷ Цанжид, А., "Монгол соёл иргэншил", УБ, 2005, 16-р тал.

Хэлний экологийн асуудал буюу аль нэг үндэстний хэл оршин байх орчныг хамгаалах тухайд, Монгол улс, монгол үндэстний өнөөгийн байдалд дулдуйдан цөөн санал бодлоо хэлье.

1. Тухайн хэлний түүхэн хөгжлийг судлах хэрэгтэй. Аливаа амьтан ургамлыг ч гэсэн хөгжил хувьслыг нь судлаж мэдэхгүйгээр хамгаална гэж байдаггүйтэй адил билээ. Монгол хэл маань гарал үүслээрээ Алтай овгийн хэлэнд багтах бөгөөд үүнд түрэг, манж түнгүүс, солонгос зэрэг хэлийг хамруулдаг. Хэв шинжийн хувьд залгамал хэл юм. Тийм учраас (agglutinative) нугармал (flexional) хэв шинжтэй англи, орос, франц зэрэг Энэтхэг-Европын хэлнээс эрс ялгаатай. Монгол хэлний үг бүтэх ёс нь үгийн язгуурын хойноос үг бүтээх дагаврууд, түүний араас үг хувилгах дагаврууд угсран залгадаг зүй тогтолтой. Монгол хэл нь түүхэн хөгжлийн явцад өвөг, эртний, дундад, орчин үе хэмээсэн хөгжлийн дөрвөн үе шатыг туулсан эртний хэлний нэг. Өнөөгийн байдлаар харьцангуй цөөн хүн хэрэглэж байгаагаар нь хэмжүүр болгож, үнэлж дүгнэх, дорд үзэн басамжилж үл болно. Ер нь хэлийг том жижиг хэмээн үзэх нь тухайн хэлээр хэдэн хүн харьцаж байна вэ? гэдгээр нь бус, хэр зэрэг эртний хэл вэ?, хэдийд бичиг үсэгтэй болсон бэ?, тэрхүү бичгээр нь хэдий хэр оюуны өв хадгалагдсан байна вэ?, хэзээнээс ном барлаж хэвлэж эхэлсэн бэ?, бичгийн хэл нь хэдий үеэс бүрэн цэгцэрсэн бэ? Ямархүү түүхэн хөгжлийг туулсан бэ? хэр баян үгийн сантай бэ? гэх мэт олон талыг харгалзан үзэх шаардлагатай. Ингэж бодож үзвэл, монгол хэл маань яах аргагүй хүн төрөлхтөний оюуны соёлын нэг хэсгийг тээж ирсэн эртний том хэл мөн билээ. Цагтаа, монгол хэл маань одоогийн Англи хэл шиг нөлөөтэй байж, олон улс орныхон зайлшгүй хэрэгцээгээ болгон сурч эзэмшиж, монгол бичгээр бичсэн албан бичиг тив дамжин өртөөлж байсан түүхтэй. Монгол хэлний түүхэн хөгжил нь нийгмийн ямар адармаатай зам мөрийг, хэрхэн туулж, өнөөгийн бидэнд өвлөгдөж ирснийг олон түмэнд бодтой баримттай таниулах нь монгол хэлний экологид туслах нэгэн зүйл мөн билээ.

2. Бичгийн хэлийг цэвэр ариун байлгах, улам баяжуулах үйл үйлдэл нь хэлний экологийн гол асуудал юм. Хувь хүний ярианы хэлийг журамлах боломж бараг байдаггүй тул бичгийн хэлийг эрхэмлэдэг нь аль ч улс үндэстний баримталдаг жишиг юм. Хэл шинжлэлийн ухаанд, зөв бичих зүй, зөв дуудах зүй, хэлзүй, найруулгазүйн тогтсон хэм хэмжээтэй, сайтар боловсорсон хэлийг бичгийн хэл хэмээн тодорхойлдог. Радио, телевиз зэргийн хэл нь аман бичгийн хэл болох тул мөн тийм тогтсон хэм хэмжээг мөрдөх ёстой. Монгол улсын өнөөгийн байдалд олон зүйл сонин, радио, телевизийн хэл найруулга тун ядмаг байгаа нь эх хэлний маань экологид сөрөг муу нөлөөтэй төдийгүй, нийт ард олны хэл ярианы соёлд гай тарьж байгааг цохон тэмдэглэе.

Нэрт монголч эрдэмтэн Б.Я.Владимирцовын бичсэнчлэн, Чингис хаан бээр “боловсорчихсон бичгийн хэл”⁸-ийг Их Монгол Улсын хэмжээнд албан ёсоор хэрэглэсэн түүхтэй. Ийм эртний уламжлалтай монгол бичгийн хэл маань XVII зууны эцэс гэхэд, зөв бичих дүрэм, хэлзүйн тогтолцоо, хэл найруулгын хувьд аль хэдий нь бүрэн төгс боловсорсон, бас харь үгийг тэмдэглэх тогтолцоот галиг үсэгтэй, орчуулганд баримтлах нарийн чанд зарчимтай сонгодог бичгийн хэл болсон. Нийгмийн түүхийн

⁸ Владимирцов. Б.Я., “Работы по Монгольскому языкознанию”, Москва, 2005, стр. 430.

хугачаа нугачаанд ороо бусгаа цагийн аяс элдэв янзаар нөлөөлж байсан боловч, ерөнхийдөө тэрхүү сонгодог бичгийн хэл уламжилсаар өнөөг хүрчээ. Монгол бичгийн хэлийг хамгаалахад өнөө цаг үед юуг анхаарах вэ? хэмээвээс:

1. Олон зуун жилийн, олон зүйл мэдлэг ухааны судар шастирын үг хэллэг, найруулгын хэв намбад эргэн суралцах нь нэн эрхэм байна. Үе үеийн монгол эрдэмтэн мэргэдийн бодрол ухаарлыг тээж ирсэн монгол бичгээ хальж сольсон төдийгүй XX зууны эхэн үеэс, өмнөх үеийн бүх бичгийн дурсгалыг феодализмын, шашны, хоцрогдсон үзэл суртлын хэмээх хоч зүүж, үзэж судлах замыг хаагаад хэдэн арван жил болсон тул залуу үе маань монголчуудын олон зууны бичиг номын их сан хөмрөгөөс суралцах нь бүү хэл, юу юу байдгийг ч мэдэхгүй нь бодот үнэн билээ. Энэ нь тэдний буруу бус, тухай тухайн үеийн төр засгийн ташаа бодлогын гай юм. Зарим хүмүүс тэгээд юу юу байгаа юм бэ? гэдэг. Ганц жишээ хэлэхэд, XIII зуунаас XX зууны эх хүртэлх үед, монгол мэргэд, монгол бичгээрээ туурвисан зөвхөн монголын түүхэн сурвалжийг сорчлон дээжилж, 30 боть цуврал болгон Их Монгол Улс байгуулагдсны 800 жилийн ойгоор 2006 онд бид хэвлүүлсэн билээ. Энэ бол өчүүхэн хэсэг шүү дээ. 1990-ээд оны эхнээс буй болсон эрх чөлөөт боломж нөхцөлийг өөрийн үндэстний эрх ашигт нийцүүлэн ашиглаж, төр засаг ч хувь хүн ч хичээл зүтгэл гаргаж, өөрийн оюуны өв хөрөнгөө сурч судлах нь монгол хүний үүрэг хариуцлага юм. Энэ бүхний ганц түлхүүр нь үндэсний монгол бичгээ л сурах явдал юм. Учир юун буй хэмээвээс, нэгдүгээрт, хэдэн улсад хуваагдсан монгол үндэстнийг нэгтгэж ирсэн ганц зүйл нь нэг зөв бичих дүрмээр бичээд, өөр өөрийн аялгуугаар уншдаг монгол бичгийн хэл, хоёрдугаарт монгол хэлний үгийн бүтцийг өчүүхэн ч алдагдуулалгүй хадгалж ирсэн монгол бичгийн хэлээс монголчуудын сэтгэлгээний түүхэн хөгжил болсон үгийн гарлыг мөшгиж болдог, гуравдугаарт, энэ бичгийг зөвхөн монголчууд л хэрэглэж ирсэн өвөрмөц содон бичиг үсгийн тогтолцоо тул монгол үндэстний ялгарах онцлог нь юм.
2. Бичгийн хэлийг тасралтгүй тэжээгч болсон нутгийн аялгуунуудыг хамгаалах учиртай. Академич Ш.Лувсанвандан бээр “Монгол бичгийн хэл нь долоон зуугаад жилийн турш тасралтгүй хэрэглэгдэж ирэхдээ ямагт үе үеийн ардын ярианы хэл, нутгийн аялгуугаар тэжээгдэн хөгжсөөр ирсэн тул мөхсөн хэл болсонгүй, болох ч нөхцөлгүй юм”⁹ хэмээн бичсэн байдаг. Ер нь олон нутгийн аялгуу оршин байх нь тухайн үндэстний хэлний дархлаа нь болдог учиртай. Ерөөсөө монгол хэл гэдэг бол монголын олон аялгууны ерөнхий нэр бөгөөд тэдгээрийг лавтай 800 жил нэгтгэн зангидаж байгаа бодот юм нь монгол бичгийн хэл юм.

Нутгийн аялгууг хамгаалах гэдэгт олон аялгуутны ардын аман зохиолын нэн баялаг арвин өв санг хамгаалж, нийт үндэстний хэрэглээнд оруулах тун чухал үйл хэргийг багтаан хэлж байна. Монгол үндэстэн энэ талаар яндашгүй баян гэдгийг хэн бүхэн мэднэ. Профессор Д.Цэдэвийн бичсэнчлэн “Хорь гучин мянган шад тууль үлгэрээс, хоёр гурван мөр шүлэг болох зүйр үг хүртэлх урт, богино бүтээлд Монголын ард түмний санах, сэтгэх онцлог, тэдний хүсэл эрмэлзэл туссан байдаг юм”¹⁰. Монгол үндэстний ардын аман зохиолын олон

⁹ Лувсанвандан.Ш., “Монгол утга зохиолын хэлийг цаашид сайжруулах тухай, Хэл, харилцаа, дохио” (Бүтээлийн түүврийн 5-р боть) УБ, 2005, 83-р тал.

¹⁰ Цэдэв, Д., “Уран зохиолын уламжлал шингэчлэлийн зарим асуудал”, УБ, 1967, 26-р тал.

төрөл зүйлийг улс орны хил хязгаарыг харгалзалгүй, монголын олон ястан, аялгуутанд уламжилсан хувилбар хувилбараар нь судлан цуглуулж, монгол хүний байнгын хэрэглээнд оруулж өгвөл, монгол хэлний экологид нэн их ачтай буянтай үйлс болох юм.

3. Монгол эх хэлээ, харь хэлний зохисгүй нөлөөнөөс хэрхэн хамгаалах вэ? гэдэг нь өнөөдрийн тулгамдсан асуудлын нэг болжээ. Орчин үеийн шинжлэх ухаан, технологийн хөгжлийн хурд, ялангуяа мэдээллийн технологийн гайхамшигт ололт амжилт нь аль нэг оронд байгаа хүнийг дэлхийн нөгөө өнцөгт буй хүнтэй, орон зай, цаг хугацааны нэгэн агшинд холбох болжээ. Бас манай улсын олон талт гадаад харилцаа жил ирэх тутам өргөжиж, хувь хүмүүс нааш цааш явалцах нь ч их боллоо. Энэ мэт нөхцөл байдалд наад зах нь гурван зүйл ажиглагдаж байна.

I. Олон зүйл шинжлэх ухааны шинэ шинэ нэр томъёо, бас зах зээл, худалдаа арилжаатай холбогдсон үгс монгол хэлэнд бөлөг цөлөгөөр орж ирэх болов. Үүн дээр, харь хэлний үг хэллэгийг чамирхал болгон хэрэглэж, өөрийнхөө “боловсролтойг” (үнэндээ ядмаг, мулгуугаа) гайхуулагчид багагүй уршигтай ажээ. Аливаа улс орон харь хэлний үг, нэр томъёог өөрийн хэлний үгээр буулгахыг хичээдэг. Тусгай ойлголт ухагдахууныг заасан нэр томъёоны зүйлийг тухайн хэлний зүй тогтол, үг бүтэх ёсонд нийцүүлэн шинэ үг бүтээн нэрлэхийг юун түрүүнд эрхэмлэдэг. Монгол хэлний тухайд, бусад хэлний нэр томъёоны зүйлийг монголоор нэрлэхдээ, шинэ үг бүтээх олон арга байхын дээр эртний бичгийн хэлний үг, олон нутгийн аялгууны үг хэллэгийг таацуулах хэрэглэх боломж ч их байдаг. Гагцхүү тухайн мэргэжлийн хүн, монгол хэлний мэргэжлийн хүн хоёр нийлж ажиллавал их үр дүнтэй юм.

II. Сурч боловсрох болон аж амьдралын шаардлагаар гадаад хэлийг сурч эзэмших нь түгээмэл хэрэгцээ болжээ. Профессор Ц.Шагдарсүрэн багш “Эх хэлээ эвдэхгүй юмсан” хэмээх номдоо “Аж төрөх шаардлагаар хүмүүс гадаад хэлийг шимтэн үзэх болсон нь энэ цаг үеийн бас нэгэн эерэг онцлог болно. Гадаад хэлтэй байна гэдэг бол өдгөө бахархал гэхээсээ илүү боловсролтой хүн бүрт байх ёстой энгийн зүйл болж байна. Тэгэхээр зөвхөн орчуулагч хэлмэрч төдийгүй гадаад хэлтэй хүн бүрийн эх хэлний боловсрол онцгой чухал. Эх хэлээ сайн мэднэ гэдэг гадаад хэлийг сайн сурах, ялгаа заагийг нь гаргаж ойлгоход хэрэг болоод зогсохгүй монгол хэлний мэдлэг, боловсрол, сэтгэхүйг хөгжүүлэх хүчин зүйл. Монгол сэтгэхүй байна гэдэг бол монгол хүн байхын гол суурь. Зарим хүн хүүхдийг багаас нь гадаад хэлтэй болгох ёстой, бага дунд сургуулийн хичээлийг гадаад хэлээр заах ёстой гэж үздэгийг цааштай нааштай үнэлвэл зохино. Ямар ч улсад албан ёсны бага сургуульд эх хэлээр нь хичээл заадаг. Хэрэвзээ багаас нь эх хэлийг нь анхааралгүй зөвхөн гадаад хэл гээд байх ахул өнөөдөртөө мэдэгдэхгүй ч яваандаа монгол сэтгэхүйгүй, монгол сэтгэхүй үгүйн улмаас монголоо гэхгүй, хаа мөнгө олдох газар цагаач болж одох иргэнийг бэлдэж байгаагаас цаашгүй болно”¹¹ гэж бичжээ. Хүүхдээ бүр цэцэрлэгийн наснаас нь гадаад хэл сургаж байгаа монгол эцэг эхчүүд чухам юу бодож байдаг юм бол?! Лав эх хэлээрээ ч, нөгөө сурч байгаа хэлээрээ ч сэтгэн бодох чадваргүй ирээдүйн монгол иргэн болох байх даа. Энэ бол шоглоом бус шууд нүүрлэсэн

¹¹ Шагдарсүрэн, Ц., “Эх хэлээ эвдэхгүй юмсан”, УБ, 2007 5,6-р тал.

эгзэгтэй асуудал бөгөөд ёстой л “Үндэсний аюулгүй байдлын зөвлөл” авч хэлэлцэх зүйл юм даа.

III. Үг нь монгол боловч махчлан буулгасан орчуулгын үг хэллэг монгол хэл, монгол сэтгэлгээг алгуур хөнөөх аюулын нэг бөгөөд бас л харь хэлний нөлөөтэй холбогдох зүйл. Социализмын үеэс орос зэрэг өрнө дахины хэлнээс махчлан орчуулсан цөөнгүй үг хэллэг өнөө үед бүр хэвших хандлагатай болжээ. Жишээлбэл:

тусламж үзүүлэх (туслах)
дэмжлэг үзүүлэх (дэмжих),
цээрлэл үзүүлэх (цээрлүүлэх),
хүндэтгэл үзүүлэх (хүндэтгэх),
хөнгөлөлт үзүүлэх (хөнгөлөх, хөнгөвчлөх)
өршөөл үзүүлэх (өршөөх)
халамж үзүүлэх (халамжлах)
дарамт үзүүлэх (дарамтлах)
шахалт үзүүлэх (шахамдуулах)

нөлөө үзүүлэх (нөлөөлөх) гэх мэтээр ярьж бичих нь бараг зуршил болжээ. Монгол хүний хэл, сэтгэлгээний онцлогоор бол “үзүүлэх” гэдэг нь харуулах гэсэн санаа бөгөөд тусламж, дэмжлэг гэдэг юмны барааг л харуулах юм байна гэж ойлгогдоно. Энэ мэт үзэгдлийн тухай профессор А. Цанжид “Монгол хэл бол уг нь аливаа зүйлийг үйлжүүлж тодорхойлдог бол европ дахины хэл нь нэршүүлэх хандлагатай байдаг. Гэтэл сүүлийн үед монгол хэлэнд ч нэршүүлэх хандлага ажиглагдах болсон билээ. Тухайлбал, монгол хэлээр өвдөх, агших гэж хэлдэг байсаар атал өвдөлт өгөх, агшилт өгөх гэх мэтээр ярих боллоо”¹² хэмээн шүүмжлэн бичсэн нь бодот үнэн билээ. Дээрх мэт алдаа нь монгол хүн чинь ийм санааг юу гэж хэлдэг билээ хэмээн өчүүхэн ч эргэлзэхгүй, толь бичиг ч үзэлгүй, шууд л үг бүрийг махчлан буулгадгийн балаг юм.

Дарга нарын үг ярианд байнга тохиолддог “өндөр ач холбогдол өгөх” гэдэг холбоо үг бий. Уул нь тухай тухайн хам сэдэв, учир шалтгаанд тохируулаад, “онцгойлон анхаарах, хамгаас чухалчлах, ихэд ойшоон үзэх, нэн эрхэмлэх” гэх зэргээр монгол хүн хэлнэ л дээ. Академич Ц. Дамдинсүрэн гуайн “Орос Монгол толь”-ийг үзвэл, “придавать значение” гэдгийг “ойшоон үзэх, тоох” хэмээн орчуулсан байх юм. Толь бичиг үздэггүйн нэг жишээ л энэ юм даа.

Иймэрхүү жишээ баримтыг цуглуулбал лавтай дунд гарын толь бичиг болох байх аа. Сүүлийн үед “хэрүүлийн алим” гэх мэт харь хэлний хэлц үгийг ч ажиггүй хэлж, бичих болжээ. “хэрүүлийн алим” хэмээх европын хэлний хэлц үгийн тухай эртний Грекийн домогт өгүүлсэн нь: *хэрүүлийн тэнгэр Эрида цугласан олны дунд “Хамгийн үзэсгэлэнтэй” гэсэн бичиг бүхий алтан алим хаяжээ. Гера, Афина, Афродита зэрэг дагинас хэн нь илүү үзэсгэлэн төгс болохоо батлах гэж маргалдаж, хэрүүл цуугиан болсоноос энэ хэлц үг гарсан гэдэг аж.* Монголоор бол “яс хаях” л юм. “хоёр нохойн хооронд яс битгий хая, хоёр нөхрийн хооронд хов битгий хэл” гэсэн сургаал үг ч бий шүү дээ. “Хэрүүлийн алим”-ыг ойлгуулах гэж хүүхэл багачуудад эртний Грекийн домог ярьж сууснаас, яс булаалдаж байгаа нохдын зураг үзүүлбэл, монгол ахуйд арай ойр биз дээ.

¹² Цанжид. А., “Монгол соёл иргэншил”, УБ, 2005, 131-р тал.

Нэрт зохиолч, эрдэмтэн Л. Түдэв гуай “Хэлний хүчирхийлэл” хэмээх цуврал нийтлэлдээ: “Сүүлийн үед түшмэдүүд өөрсдийгөө “нээлттэй хүн” гэж зурагтаар магтуулан ярьдаг болсон. Гэтэл тэр хүний юу нь ч “нээгдээгүй” (нээх цонх, хаалга байхгүй) харагддаг. Энэ нь орос мэтийн харь хэлнээс үг авахдаа шууд “калык” гэдэг нимгэн цагаан цаас тавьж байгаад, гэрэлтэн буй зургийг яг тэр чигээр нь хуулж авдагтай адил үйлдэл (хальслалт) юм. Монголчууд нээлттэй хүн гэж ярьдаггүй, харин “илэн далангүй хүн” гэдэг билээ.

Түшмэдүүд бас “анхаарал тавина” гэж бараг цөмөөрөө ярьдаг нь яг л цагаан сараар “ууц тавина” гэсэнтэй адил санагддаг. Анхаарал бол хийсвэр ойлголт тул барьж, тавиад байх аргагүй. Харин анхаарч буюу анхаарахгүй байж болно. Тэгвэл “анхаарна”, “анхаарсанд баярлалаа” гэвэл илүү үггүй цэвэр хэллэг болох биз ээ” хэмээн бичсэн нь махчлан буулгасан мэдгээ эс ухаарагсдад чухал санамж болжээ.

Харь хэлний үгийг хуулбарлан буулгах нь наана хэлэхэд, монгол хүний ой тойнд орж ухагдахгүй, цаана хэлэхэд, эх хэлнийхээ зүй тогтлыг эвдэхийн үүдийг нээж буй хэрэг юм.

Монгол хэл гэдэг чухам ямар түүхтэй болох, монгол бичгийн хэлийг цэвэр ариун байлгахын утга учир, орчин цагийн монгол хэлэнд, харь хэл хэрхэн нөлөөлж байгаа тухай өөрийн санааг, эрдэмтэн судлаачдын бодолтой сүлэлдүүлэн товч ярилаа.

Төгсгөлд нь монгол хэлний экологи буюу монгол хэл, бичгээ хамгаалах, тийм боломжит орчныг хадгалахад давын өмнө анхаарах юу юу байна вэ? гэдгийг товч өгүүлэе.

1. Хүн төрөлхтний хэлийг амьтан, ургамлын ертөнцтэй зүйрлэвэл, түүний нэгэн томоохон төрөл зүйл нь монгол хэл, бичиг юм. Амьтан ургамлын төрөл зүйлийг хамгаалахад, гарал үүслээс аваад, өнөөгийн тархац хүртэл судлаж, бүх талын орчин нөхцөл хэрхэн нөлөөлж ирсэн, одоо ямар байгаа зэргийг хамтад нь авч үздэг ажээ. Монгол хэл, бичгээ хамгаалж, хадгалж, боловсруулан хөгжүүлэх нь түүн лүгээ адил хэмээж болно. Монгол хэл бичгээ сайн мэдэж байвал, хамгаалах болон, боловсруулан хөгжүүлэх арга замыг олж харна.

2. “Хэлийг хамгаалах нь улс үндэстний, хамт олны үйл хэрэг боловч, тухайн хэлийг өвлөн авч яваа хувь хүний идэвх зүтгэлээс шууд хамаарна”¹³ гэж хэл шинжлэлтнүүд бичжээ. Энэ бол гарцаагүй үнэн. Та монгол хүн юм бол, монгол хэл, бичгээ зайлбаргүй мэддэг байх ёстой хэмээсэн бичигдээгүй хуулийг хэрэгжүүлж, бас монгол хэлээ мэддэггүйгээ мэддэггүй хүмүүсийг ухааруулах аваас монгол хэлний дархлаа буй болно. Энэ нь үндэстний аюулгүй байдал, улс орны тусгаар тогтнолтой шууд холбогддог тул төр, засгаас зохих хууль, эрхзүйн орчныг бүрдүүлж өгч, бас байнга анхааран хянах ёстой буй за. 1640 оны “Их цааз”-д “Сайдуудын (ихэсийн) хөвгүүд монголд (монгол бичигт) эс сэхээрэхүүнээ (эс сурваас, эс тайлагдваас), эцгээс нь гунан (шүдлэн) морь аваад, хөвгүүнийг нь багшид өгч сурга. Олонд танигдах хүний гунан(шүдлэн) хойн (хонь), олонхи муугийн (ерийн харцасын) арван таван мөнгө хөвүүгийн нь багшид өгч сургах нь урьд мэт. Хөвүүн нь нас арван тав хүртэл эс сэхээрэхүүнээ (эс сурваас, эс тайлагдваас) цаазтай(ялтай)”¹⁴ хэмээн заасныг ташрамд тэмдэглэе.

¹³ Хроленко, А.Г., Бондалетов, В.Д., “Теория языка”, Учебное пособие для студентов, аспирантов и преподавателей - филологов, Москва, 2004, стр.400.

¹⁴ Батбаяр, Б., “Их цаазын эх бичгийн судалгаа” УБ, 2008, 68-р тал.

3. Үгээр тоглогчидтой тэмцэх хэрэгтэй. Эх хэлнийхээ үг бүрийг, эх орныхоо чулуу бүрийг хамгаалах цаг үе иржээ. Аливаа хэлний үг гэдэг үнэ цэнэтэй, ид шидтэй, нарийн нандин зүйл. Үг бүрийн цаана тухайн үндэстэн угсаатан бээр уг юм үзэгдлийг аль талаас, хэрхэн ухаарсныг тусгасан хэл сэтгэхүйн сонин содон дүр төрх байдаг. Жишээ нь, хэн бүхний мэддэг “урлаг” хэмээх үг нь монгол хүний ухаарлаар бол ур ухаанаар баялаг юм ажээ. Энэ нэгэн ухагдахууныг оросоор “искусство” (эртний слав хэлний “искоусть” → испытывать → амсаж үзэх, турших гэсэн үгээс гарчээ), германаар “Kunst” (können- чадах гэсэн үгээс гарчээ), латин хэлээр “art” (уг үгийн язгуур нь хийж бүтээх гэсэн утгатай ажээ), грек хэлээр “τέχνη” (үүсгэх, буй болгох, төрүүлэх гэсэн язгуур утгатай ажээ) гэх мэтээр нэрлэх¹⁵ бөгөөд үгийн гарал нь тухайн хэлтний сэтгэлгээний онцлогийг харуулах ажээ.

Ийм онцлогийг профессор Чой. Лувсанжав багш бээр тодруулан өгүүлэхдээ “Монгол хэлийг монгол соёлын том музей хэмээн бодвоос, монгол хэлний үг бүр тэр музейн нэг сонин үзмэр хэмээлтэй” гэсэн байдаг

Эх хэлнийхээ үг хэллэгт хайш яйш бүү хандаач хэмээн, төрийн түшээдээс эхлээд, бизнес арилжааны эрхмүүдэд тухайлан гуйн хүсье.

“Хүн – хэл, бичиг – бизнес”, “Хүн – хэл, бичиг - бараа” гэсэн сурталчилгааны орчилд монгол үг хэллэгийг зөв оновчтой, уран яруу хэрэглэх нь арилжаанд ч тустай, бүх нийтийн эх хэлний боловсролыг эвдэхгүй байхад ч хэрэгтэй юм. Ядахдаа, харь хэлний үг, үсгээр төөрөгдүүлэхгүй байвал сайн сан.

Монгол хэлний нийтийн хэрэглээний төвшинд уг үгийн гарал үүсэлд нь хүртэл нарийвчлах шаардлага тэр бүр байхгүй ч, үг бүрийн бүтэц, найруулгын өнгө, ойролцоо болон эсрэг утгатай үг, ямар үгтэй найрч, ямар утгыг илтгэдэг, зөв бичих дүрмийн учир холбогдол, монголчуудын аж төрөл, ёс заншил, шашин шүтлэг ур ухааны онцлогийг илтгэдэг хэлц хэллэг зэргийг мэдэж байх нь боловсролтой монгол хүний энгийн шаардлага юм.

Профессор Ч. Онгоодой бээр “Тадаад хэлээр уншиж, бичиж ойлгодог байх нь нэг хэрэг боловч, эх хэлнийхээ яруу сайхныг мэддэггүй, бичих найруулах авъяасгүй бол нэн гачлантай. Үг эвлүүлж, өгүүлбэр зохион, судар ном бүтээх нь тоосго өрж, орд харш босгохтой адил. Өндөр нам өрж, өнцөг буланг нь жигдлээгүй тоосго, барилгыг ямар болгох вэ? Гэгээн оюун зарж, үгийн “тоосгоор” өрж босгосон номын их суврага ч үүнтэй утга дүйх бус уу. Үг сонгож зөв найруулах нь нарийн өрлөг шаарддаг чимхлүүр ажил юм”¹⁶ хэмээн, мэргэжил огт өөр боловч, эх хэлээн энхрийлэгчийн сэтгэлээр бичсэн байдаг. Үг сонгох, зөв найруулах, үгийн нарийн өрлөг хийхэд, эх хэлний үгийн сангийн баялаг мэдлэг, монголоороо сэтгэн бодох чадвар, монгол хэлнийхээ зүй тогтлоор бичих, сэтгэх чадамж, үг хэлхэж, өгүүлбэр бүтээн, утга төгс санааг илэрхийлэх дадлага туршлага байж гэмээ нь бийр барьж, бэх цаас нийлүүлэх эрхийг олох буй заа.

Дээрх чадвар нь ээжийн бүүвэйн дуунаас эхлээд, эцэг эхийн хэл яриа, эрдмийг амлуулагч багшийн заах хичээл, эх хэлний яруу тансагийг агуулсан уран зохиолын ном, толь бичиг сэлтийг дамжиж, бас өөрийн үргэлжийн чармайлт мэрийлтээр буй болдог юм. Ийм чармайлт гаргах, эсэх нь би монгол хүн гэсэн чин сэтгэл, үзэл бодол төлөвшсөн, эсэхээс шууд хамаарна.

¹⁵ Камчатнов, А. М., Никселина, Н. А., “Введение языкознание”, Москва, 2004, стр 39.

¹⁶ Онгоодой, Ч., “Үг нь монгол, өгүүлбэр нь орчуулсан хэлнийх байж болохгүй”, Таван ухаан (сонин), 1999 оны №9(29).

Дагестаны алдарт зохиолч Р. Гамзатов “Дэлхийн улс түмний олон хэл нь тэнгэрт түгсэн одод мэт надад санагдана. Тэрхүү оддын чуулганыг нэгэн аварга том од болж бүү нийлээсэй хэмээн би хүснэм, Яг нар шиг! Од бүхэн гэрэлтэн сацарч байг! Хүн бүрийн хэл ч өөрийнхөө од шиг оршиг! ”¹⁷ хэмээсэн яруу бэлгэт үгийг эшлэхийн ялдамд, монгол хэл, бичгээ монголчууд бид л хамгаалж, өөрийн юмыг өөд нь татаж эс авбаас, өрөөл бусад туслах нь үгүй шүү гэдгийг цохон хэлье.

SUMMARY

One issue of the language ecology is to keep written language pure and enrich it. Ecology of the language is a root of the ecology of culture. It closely relates to the independence of a country. The author discusses the negative aspects that occur in the ecology of the Mongolian language with facts and suggested the way to correct them.

¹⁷ Хроленко, А.Т., Бондалетов, В.Д., "Теория языка", Учебное пособие для студентов, аспирантов и преподавателей - филологов, Москва, 2004, стр.420.